



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Ногдол ашиг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76.1.12-р заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02-р сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2025 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 10 төгрөг 69 мөнгө (арван төгрөг жаран есөн мөн)-өөр тогтоосугай.
2. “Гермес центр” ХК-ийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03-р сарын 9-ний өдрөөр тасалбар болгосугай.
3. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны сүүлийн хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2026 оны 03-р сарын 16-ны өдрөөс эхлэн хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн харилцах дансанд болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-тай гэрээ байгуулан 2026 оны 4-р сарын 15-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан тараахыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН